

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД, САНГИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2008 оны 7 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 140/271

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 270 дугаар тогтоолын 3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, "Төлбөрт үйлчилгээний үнийн жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Шүүхийн шинжилгээний үндэсний төв /Ч.Алтанхишиг/-д даалгасугай.



Хууль зүй, дотоод хэргийн сайд,
Сангийн сайдын хамтарсан 2008 оны
р тушаалын нэгдүгээр хавсралт

170/221

Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журам

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоол, шийдвэрээр шүүх эмнэлгийн амбулаторийн гэмтлийн зэрэг тогтоох үзлэг, лабораторийн болон магадлан шинжилгээ хийхэд шаардагдах ажил үйлчилгээний төлбөр гаргуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Хувь хүний хүсэлтээр нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээг төлбөртэйгээр хийж үйлчилхэд энэ журмыг мөрдөнө.

Хоёр. Төлбөртэй хийх үзлэг, шинжилгээний төрлүүд

2.1. Амбулаториор хийгдэх гэмтлийн зэрэг тогтоох үзлэг, лабораторийн шинжилгээ

2.2. Цогцост магадлан шинжилгээ хийх

2.3. Шарил шинжлэх

2.4. Цогцос хадгалах

2.5. Хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй цогцос оршуулах

Гурав. Төлбөр гаргуулах нөхцөл

3.1. Эрх бүхий байгууллагын шийдвэр, тогтоолоор хийж байгаа амбулаторийн үзлэг, лабораторийн шинжилгээний төлбөрийг үзлэг шинжилгээ хийлгэж буй иргэн гаргана.

3.2. Цогцост магадлан шинжилгээ хийх, ар гэрийнхэний хүсэлтээр шарил шинжлэхэд талийгаачийн ар гэрийнхэн төлбөрийг хариуцана.

3.3. Гэмт хэрэг илрүүлэх зорилгоор мөрдөн байцаах, прокурор, шүүхийн байгууллагын шийдвэрээр шарил шинжлэхэд гарсан зардлыг шинжилгээ хийх тогтоол гаргасан тухайн байгууллага хариуцана.

3.4. Хэн болох нь тодорхойгүй, хариуцах эзэнгүй цогцосны ар гэрийнхэн нь тодорч ёс заншлын дагуу дахин оршуулах хүсэлт гаргавал цогцосыг оршуулсан газраас нь гаргаж өгөх, тээвэрлэх, хадгалах зардлыг төлүүлнэ.

3.5. Амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой, нэн ядуу иргэдийг холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн төлбөрөөс чөлөөлж болно.

Дөрөв. Төлбөрийн мөнгийг хураан авч төвлөрүүлэх, зарцуулах

4.1. Төлбөрийг Шүүхийн шинжилгээний үндэсний төв, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны дансанд төвлөрүүлнэ.

4.2. Төлбөрийн мөнгөний орлого, зарцуулалтыг тайлан тэнцэлд тусгаж, түүнд төвийн удирдлага, албадын дарга нар түүнд хяналт тавина.

4.3. Төлбөрийн мөнгийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр дараах арга хэмжээнд зарцуулна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд,
Сангийн сайдын хамтарсан 2008 оны
-р тушаалын хоёрдугаар хавсралт

170/24

Төлбөртэй үйлчилгээний үнийн жагсаалт

№	Төлбөртэй үйлчилгээний төрөл	Төлбөрийн хэмжээ /төгрөгөөр/	
Амбулаториор хийгдэх үйлчилгээний төрөл			
1.	Гэмтлийн зэрэг тогтоох магадлан шинжилгээ	3000	
2.	Нарийн мэргэжлийн эмчийн нэмэлт үзлэг /нүд, чих, хамар хоолой, эмэгтэйчүүд/	5000	
3.	Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хийж буй бэлгийн гэмт хэргийн шинжилгээ	5000	
4.	ЭХО-д харуулах	3000	
5.	Рентген зураг авах	2500	
6.	Компьютер томографийн зураг унших	3000	
7.	Рентген зураг унших	1500	
8.	Цусны бүлэг тогтоох	1000	
9.	Иргэний хүсэлт, шүүхийн шийдвэрээр хүүхдийн эцэг тогтоох шинжилгээ	Эцэг тогтоох биологийн шинжилгээ /ийлдсээр/	40000
		ДНХ-ийн адилтгах шинжилгээг 6 локусаар хийх /3 хүн-эцэг, эх, хүүхэд/	147000
		ДНХ-ийн адилтгах шинжилгээг 13 локусаар хийх /3 хүн-эцэг, эх, хүүхэд/	180000
10.	Бактерлогийн лабораторийн шинжилгээ	5000	
11.	Хуулийн байгууллагын шийдвэрээр хүний цус, шээсэнд этилийн спирт тогтоох шинжилгээ	2000	
12.	Эдийн шинжилгээ /биопси/	биопси	5000
		цитологи	3000
Цогцост хийх шинжилгээ, үйлчилгээ			
13.	Үүнээс:	Насанд хүрэгчийн цогцост хийх магадлан шинжилгээ	40000
		Цогцос задлан шинжлэх	13000
		Этилийн спирт тодорхойлох	2000
		Эд эсийн шинжилгээ	5000
		Цусны бүлэг тогтоох	1000
		Засал хийхэд	2000
		Нэмэлт шинжилгээ: - хорт болон мансууруулах бодис хэрэглэсэн эсэх, бусад лабораторийн шинжилгээ	17000
14.	Хүүхдийн цогцос магадлан шинжлэх/ 0-16 насны /	20000	
15.	Орон нутгаас ирүүлсэн цогцосноос авсан эд эрхтэний дээжинд эм, хорт болон мансууруулах бодис тодорхойлох	5000	
16.	Шүүх эмнэлгийн шинжилгээ хийгдсэн цогцос нь 3-с дээш хоносон тохиолдолд иргэдийн хүсэлтээр хөргөгчид хадгалахад / 1 хоногт/	5000	
17.	Иргэдийн хүсэлтээр цогцос хөргөгчид хадгалах /1 хоногт/	5000	
18.	Шарил дахин шинжлэх /экскумац/	50000	

Бусад үйлчилгээ			
19.	Гадаадын иргэний цогцос магадлан шинжлэх		500000
20.	Цогцос зориулалтын машинаар тээвэрлэх /км тутамд/		500
21.	Хэн болох нь тодорхойгүй цогцосыг оршуулсаны дараа ар гэр нь тодорч, ёс заншлын дагуу оршуулах хүсэлт гаргавал цогцосыг оршуулсан газраас нь гаргаж өгөх ажлын болон тээвэрлэлтийн зардлыг төлүүлэх		45000
	Үүнд	Тээвэрлэлт	30км х 500 = 15000
		Ажлын хөлс	30000

_____ о О о _____